

ӨВӨГ ДЭЭДСИЙН САЙХАН УЛАМЖЛАЛААС . . .

С.Дүнчээ, профессор, МУБИС

Abstract: Mongols have long historical traditions to bring up and care of young generation, to educate and give them the most appropriate knowledge, and form them into men through manual works. More precisely, the article intends to discuss some ideas of how Mongolian parents have paid their great attention, love and care to their children while teaching them traditional ethical knowledge about Dos and Don'ts in Mongolian culture such as the way of thinking, acting and living in their society.

Those issues such as what love is, the expression of love, good and bad deeds, family education for boys and girls, differences in men and women relationship, showing their love and care for their parents, good and healthy parenthood, the factors that strongly influence on the intergenerational equity, and finally the greatest importance of reading books for healthy mind and body have been discussed.

Finally, the article is the attempt to remind that the educational organizations such as schools, kindergartens, teacher educators, education policy makers, education planners and managers, parents as well as neighbors should cooperate with one another. The current situation proves that only kindergartens and school can make children more intelligent, knowledgeable and well-disciplined, but it is a big mistake. The cooperation of all the related organizations and people can make any actions for children happen while recombining the old traditions with the reforms.

Түлхүүр үг: боловсрол, мэдлэг, хүмүүжил, хөгжил, хайр, эх оронч үзэл

Соёлт хүн төрөлхтөн өнөөгийн нөхцөлд та бидний амьдарч буй энэхүү цаг үед залуу үеийнхээ ирээдүйн амьдрал хөгжилд маш их анхаарч байна. Хүмүүжил - ёс суртахууны хамгийн нандин чанар болох эелдэг зөөлөн, шударга, үнэнч, даруу, дуулгавартай, ахмадыг хүндэтгэдэг, аливаа юманд хайр гамтай хандах талаар өнцгой анхаардаг болов. Манайд ёс суртахууны нэн чухал хэсэг болсон харилцааны соёл үнэхээр доголдож байгаа. Бодоод үз. Их сэтгэгч Ф.Энгельсийн хэлснээр “хөдөлмөр хүнийг буй болгосон” нь маргашгүй үнэн. Тэгвэл хүмүүс хоорондын харилцаа тэдний хөгжлийн судас байсан, өдгөө ч байна. “Эвт шаазгай буга барина”. Зөвхөн хүнд байдаг “хайр”

бол угтаа хүмүүс хоорондын харилцааны нэг хэлбэр. Эрдэмтэд:

1. Эх хүн хүүхдээ хайрлах,
2. Эцэг хүн хүүхдээ хайрлах,
3. Хүүхэд эх, эцгээ хайрлах,
4. Хүүхэд, өсвөр насныхан нэг нэгнээ хайрлах,
5. Эсрэг хүйстэн бие биенээ хайрлах хайр гэж ялгаж үзсэн байдаг.

1. Хайр ба харилцаа

Хайр бол сэтгэлийн эерэг харилцаа бөгөөд хүүхэд бие хүн болж төлөвшихөд түлхэц болдог өвөрмөц хүчин зүйл, хүүхэд яваандаа биеэ даах (өөрийгөө тодорхойлох), нийгэмд байр сууриа олох, өөрийгөө таньж мэдэх, амьдралын үнэ цэнэ харилцааг бие дааж боловсруулахад нөлөөлдөг. Эцэг, эхийн хамгийн их анхаарах ёстой, санааг нь “зовоодог”, “баярлуулдаг” үйлийн нэг “хайрыг хайрлаж” ээж, аав хүүхэдтэйгээ чин сэтгэлээс илэн далангүй ярилцаж байвал зөв гарц тэр. “Хайр хүнд аз жаргал бэлэглэнэ, бас аз жаргалыг сүйтгэнэ”. “Үрээ хайрлахыг тахиа ч чадна, харин тэднийг хүмүүжүүлж чадах нь авьяас билэг, амьдралын өргөн мэдлэг шаардсан засаг төрийн томоохон ажил мөн. Хүүхдийн тавьсан асуултад: “Яаралтгүй, том болоод мэддэг болно” гэж хэлэх нь тэдний сурч мэдэх эрмэлзлэлийг бөхөөдөг” гэж Горький хэлсэн билээ.

Манай ард түмэн эрт дээр үеэс өөрийн сурган хүмүүжүүлэх арга барилын тогтолцоотой байсан ба энэ нь эрдэмтэн, зохиолч Ш.Гаадамба багшийн “МНТ”-г судалж тодорхойлсноор эртний үгийг иш татаж, өвгөдийн үгийг үндэс болгож сургаж сурах зарчим, сайн туршлагыг “хууль” болгож, муу үйлийг “гэсгээл, цээрлэл” болгож байснаас илт.

Энд Тэмүүжин, Хасар хоёр өөр эхээс төрсөн дүү Бэгтэрийг харваж алсанд Өэлүн эхийн зэмлэж хэлсэн үг; Алун-гуа эхийн 5 хүүхдээ суулгаж байгаад 5 мөс (нарийн мод буюу сум) нэг нэгээр нь, дараа нь багцалж байгаад хугалуулж хэлсэн үг; Чингис хаан охин Алха бэхээ Арсланд эхнэр болгож өгөөд сургаж хэлсэн захиас; “Чингис Богдын есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шаштир” зэргийг эх зохиолоос нь уншаад үзэхэд тодорхой.

Монголчууд эе эвийг хичээсэн, эцэг хүүхдийн элбэрэл хайрыг илтгэсэн, анд нөхөд, цэцэн билэгт ядуу хүүгийн сургамжтай үгийг сонсох ямар ач холбогдол, учир утгатайг багш, эцэг эх, төрийн бус байгууллагынхан маань эх зохиолоос нь уншаад, уншсанаа цуглаж ярилцаад хүүхэддээ сонирхуулж хэлж ярьж бай. “Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай дээр”.

2. Буян ба нүгэл

Хүүхэд залуучуудыг бүр багаас нь дөнгөж хөл хэлд орох үеэс нь “болно”, “болохгүй”, “сайхан”, “муухай” гэж үгний учир холбогдолд сургадаг уламжлалтай.

Арван цагаан буян (сайн үйл):

1. Хорхой шавж ч байсан гэм зэмгүй амьтныг алж хөнөөхгүй, аварч хамгаалах.
2. Харамч хүнд гомдохгүй, харин өөрөө өглөг өгөх.
3. Алив үйлд буруу харилцахыг тэвчиж, зөв зохисыг эрхэмлэх.
4. Хов зөөх, хутгаж үймүүлэхгүй, тайван амарлангуй хандах.
5. Худал хэлэхгүй, үнэн шударгаар өгүүлэх.
6. Хатуу ширүүн үг хэлэх, хэрцгий зан авир гаргахгүй, эелдэг харилцах.
7. Далдуур ашиг хонжоо бодолгүй, чин санаагаа ил тод хэлж байх.
8. Бусадтай шөргөлдөх, хорт сэтгэл агуулахыг тэвчиж, сэтгэлийн үгээ илэн далангүй хэлж ярих.
9. Аливаа үйлд хомхой шунаг сэтгэл гаргахыг цээрлэж, хүнийг хайрлаж, өрөвдөж, туслахыг хичээх.
10. Хүний эсрэг элдэв буруу үзэл үйлийг тэвчиж, эе эвийг хичээж хүмүүнлэг сэтгэл гаргах.
11. Ахмад настан, зовж зүдэрсэн, нялх балчир хүн амьтанд сэтгэл гаргаж туслах. Хүний тусыг мартахгүй байх.

Арван хар нүгэл (муу үйл):

1. Гэм зэмгүй амьтны амь хороох, гал түймэр тавих.
2. Хулгай дээрэм хийх.
3. Худал хэлэх, гүтгэж гүжирдэх.
4. Садар самуун, шалиг завхай үйлдэл.
5. Хов зөөх, хутган үймүүлэх (хүмүүсийн хооронд яс хаях).
6. Харааж зүхэх, муу үгээр дайрах.
7. Ховдог хомхой зан авир гаргах, шулж мөлжих.
8. Хүйтэн цэвдэг сэтгэл гаргах, сэтгэлд сэв суулгах.

9. Хүнийг хялайн харах, өш хонзон санах.
10. Тэрслүү ааш авир гаргах, шулж мөлжих, доош дарах, өө сэв эрж элдвээр муучлах.

3. Хүмүүжил ба хүншүүлэх

Зориуд тэмдэглэхэд монгол хүн өөрийгөө егүүтгэж амиа хорлохыг бусдын амь хороосон нүгэлтэн гэж үзэж оршуулах газар зааж өгөхгүй, зан үйл хийхгүй, оролцохгүй уламжлалтай байсан. “Муу санаа эзнээ одог”, “өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр”.

Манай монголчуудын хүүхэд залуучуудаа сургаж хүмүүжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааны үндэс нь эртнээс уламжилж ирсэн хүншүүлэхэд чиглэгдэж байв. Зарим жишээ хэлье. Эрэгтэй хүүхэд эцэг, эх амьд ахуйд сахал тавихгүй, гэрлээгүй бол гэр орондоо авгай хүүхэн дагуулж ирэхгүй, архи уух, тамхи татахыг цээрлэнэ. Малгайны саравч буруу харуулж өмсөхгүй (үхсэн хүнтэй ажиллахад малгайгаа буруу харуулж өмсдөг), аав ээж, ахмад хүмүүсийн дэргэд элдэв завхай, шалиг, хараалын үг хэлэхгүй, урдуур нь гүйж харайж, дээд талд нь суухгүй, “аавын буйд хүнтэй танилцаж, агтны буйд газар үзэх”, нүүх, гэр барих, уналга, ачлагатай холбоотой ажилд эрхэмлэн суралцахаас гадна эхнэр авч өрх тэргүүлэх болсноор аж амьдралаа яаж төвхнүүлж авч явах, алс хол аян жинд явах, цэргийн алба хаахдаа баримтлах ёс зүйг сургаж хэлдэг байв. Онцолж сонирхуулахад, хар тамхи татаж байгаа газрын салхины доогуур ч гарахгүй, алуулж амь тавин чарлаж байгаа гахайн дууг сонсохгүй байхыг онцгойлон захидаг байж. Энэ бол үр хүүхдээ муу муухай зүйлээс хол байлгах гэсэн эцэг, эхийн сургаал юм. Ямар ч үед сайн үйлсэд тэмүүлдэг, сайн сонсож харилцдаг, оюун санаагаа гэгээрүүлж сэтгэлээ ариусгадаг байвал хүн болж төрсний үр шим гарна. “Сайн явбал сарны гэрэл, муу явбал могойн хор”.

4. Сав ба шим ертөнц

Хүүхдийг эр, эм ялгаагүй 3-4 настайгаас нь хавчаахай нумаар харвах, морь унахад сургадаг байсныг гадаадын жуулчид тэмдэглэсэн байдаг.

Монгол хүүхэд багаасаа 5 хошуу мал маллах, ус бэлчээр ашиглах, нутгийн өвс ургамалтай танилцах, жилийн 4 улирлын байдалтай зохицсон хөдөлмөрийн онцлогийг мэдүүлдэг байв.

Хүүхдийг багаас нь байгаль хамгаалах үйлсэд сургахыг чухалчилдаг байв. Жишээ нь, гал түймэр тавих, гэм зэмгүй амьтны амь хороох, шувууны өндгөнд сүүдрээ тусгах, гар хүрэх, шоршоолжны үүр сэндийчлэх, нялх төл төрөх

гэж байгаа амьтныг үргээж цочоох, нялх ногоо, ялангуяа бусдаас онцгойлон ургасан мод, сөөг, сонгино мэтийг зулгаах, хугалах, түүх, булаг шандны усны эхийг бохирлох, бохир саваар ус авах зэргийг цээрлэж сургадаг байлаа. Энэ нь хэлж ярихад өчүүхэн сургамж мэт боловч угтаа сав ертөнц буюу амьгүй байгаль (үүнд агаар, халуун хүйтэн, ус, хөрс хамаардаг), шим ертөнц буюу амьд байгаль (энд ургамал, амьтан, бичил бие махбод хамаардаг)-тай харьцаж сурахыг хэлж байна. “Хүн байгальтай яаж харьцаж байна, ойр дотны хүмүүстэй тэгж л харьцдаг”. Иймээс л монголчууд үр хүүхдээ багаас нь ургамал, амьтан малд ойр байлгахад онцгой анхаардаг.

5. Ураг ба удам

Монгол уламжлал - монгол сурган хүмүүжүүлэх ухаанд **охид - эмэгтэйчүүдийн** амьдрал ахуй, зан заншлын уламжлалын талаар үлэмж анхаарсан байдаг. Монголын уламжлалаар охин хүүхдийг голдуу хоёр, дөрвөн настайд нь даахь (өрөвлөг) үсийг үргээдэг (эрэгтэй хүүхдийн үсийг гурав, таван настайд нь авдаг). Бага насны охидын толгойн хоёр талд сөөг үс буюу сонжлого, зарим нутагт сонжуу гэдэг үс үлдээж бусдыг нь хусаж авдаг. Монгол уламжлалаар охидын сонжлого үс “би эхээс төрсөн биеэр байна шүү” гэсэн содон тэмдэг. Харин бэлгийн боловсролын үе болоод ирмэгц үсээ битүүлж ургуулаад ард нь сүлждэг. Энэ бол бэлгийн харилцаанд орж болно гэсэн тэмдэг. Монгол охид эмэгтэйчүүд аав, ээжээ машид хүндэтгэж, асарч халамжлахын хамт хэдүй нас бие гүйцлээ ч тэдний хажууд байхдаа хүүхэд төрүүлэхээс эмээдэг. Хоноцын хүүхэд, бутач хүүхэд гэхчлэн сайнгүй ханддаг байв. Хэрэв охин нь хүнтэй суухаар бол тэр хүний удам судрыг судалж байж өгнө. “Удам муутын үйлс хар”, “Усны эх нь булингартай бол адаг нь булингартай”. Нөхөр болох хүний тал ч хүүхний талыг судалж сураглана, сонгоно.

Монгол уламжлалд охид эмэгтэйчүүдийн үс гэзгэнд их анхаарч байв. Эмэгтэй хүн үсээ задгайлж урд руугаа унжуулахыг гашуудлын шинж гэж үздэг. Үсээ авхуулах, задгай энгэр захтай хувцас өмсвөл эр, эмийн үйл хийхгүй болсон гэсэн санаа. Манайд дээр үеэс дутуу хүүхэд гаргах, ураг хөндүүлэхийг нэн эмзэглэж хүлээж авдаг байсан. Ер нь ураг хөндүүлэх, зориуд зулбуулах нь нэгэнт олж тээсэн үрээ өөрөө амийг нь тасалж буй хар нүгэл, харгис үйлдэл, ийм хүний үйлс яаж өөдлөх билээ. Гэтэл жирэмслэхээс хамгаалах арга цөөнгүй байгаагаас гадна уламжлалт арга байсныг бодмоор. Тэр нь

тэвчээр. Нөхөр нь 3-5 жил цэрэгт явах юмуу олон сараар аян жинд яваад ирэхэд эхнэр нь тэвчээд л мал сүргээ өсгөөд л хүлээж байдаг. Өөр нэг сонирхолтой арга нь байгаль эрхэстэй холбоотой арга юм. Тухайлбал, сарын 15, битүүнд сар нарны татах хүчний дэлхийд нөлөөлөх үеэр, шинийн 18, зулын 25-ны өдөр, тэрчлэн нар сар хиртэх, салхи шуурга, дуу цахилгаантай бороотой үед, тэрчлэн бие сэтгэцийн өвчин эмгэгтэй, тамхи, архи, мансууруулах бодис хэрэглэсэн, айж цочирдсон, сэтгэлийн зовиуртай байхад бэлгийн ажил хийдэггүй байсан ба энэ нь угтаа жирэмслэхээс хамгаалах, эрүүл хүүхэд төрүүлэх чухал үндэс, арга болж байв. Бас жирэмслэх, төрөх үеэ улирлын байдалд зохицуулдаг байсан аж. Нэгэнт жирэмслсэн бол амар тайван байлгаж, сайн хоол унд өгч, хүүхдийг гэдсэнд таргалуулахгүйн тулд зохих хөдөлгөөнтэй байлгадаг. Жирэмсэн эхнэрийн дэргэд муу үг хэлэлцэх, хэрэлдэх, муухай үйл харуулахыг цээрлэдэг.

Монгол хүний нэг гайхам уламжлал бол эхийн сав - умайг ариун байлгахад оршдог. “Эрүүл эцэг эхээс эрүүл хүүхэд төрнө”. Эхийн ачийг магтсан шүлэг, дуу, зохиол олон байдаг ч яг урт насалж удаан жаргуулахын төлөө, өвчин зовлонгоос гэтэлгэхийн тулд үр хүүхэд, ач зээ нар нь юу хийж гийгүүлдэг нь сонин. Аав ээжийгээ амьд сэрүүн байхад нь санаа сэтгэлийг нь зовоож, чихэнд нь муу үг, үйл дуулгалгүй, мөр бүтэн, гэдэс цагталан явуулах нь нас барсан хойно нь алтаар хөшөө босгосноос хавьгүй илүү ач тус. Аав ээжийгээ амар жимэр байлгаж, ачилж тордож байсан хүн хожим аз жаргалтай явдаг. Энэ чанар бол Монголчуудын хамгийн дээд уламжлал байв.

6. Эхийн ачлал

Монгол заншлаар ундтай, устай, гарсан орсон хүнд, хол ойрын зочин гийчид, айл саахалтынханд, нүүдлийнхэнд тавагтай идээ, аагтай цайгаар дайлсан сайхан ааштай сайн бэр - эхнэр гэж алдаршуулдаг. Үүний эсрэг хүнд аяганы ам зуулгадаггүй, эрт унтаж орой сэрдэг, үйлэнд муу, зан ааш тааруу эхнэр гэж бий. “Үйлэнд уран, үгэнд цэцэн бэр”. Монгол ёсоор айлын “эцэг нь асралтай, эх нь энэрэлтэй, дүү бишрэлтэй, хүү тахимдуу” байна. “Эцэг эх хоёр нь арга билэг хоёр”.

Зовсон, зүдэрсэн, өндөр настан, бага балчир хүүхэдтэй зав чөлөө муутай, ам бүл цөөнтэй айл саахалтынханд хонь малын ээлжинд явах, ус цас авч, аргал түлш түүж туслах, алдсан мал сүргийг нь олж ойртуулж өгөх, гэр орныг засч янзлах, нүүлгэх суулгах гэхчлэн тус дэм үзүүлдэг сайхан

уламжлал, буянтай үйлс байсан, өдгөө ч байна. “Зовох цагт нөхрийн чанар танигддаг”, “Аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ”, “Хүнд тус болбол өөрт тус ирдэг”. “Саахалт айлын санаа нэг”. “Айл хүний амь нэг”.

Манай эхчүүд хүүхдээ гурав, заримдаа дөрөв, таван нас хүртэл нь хөхүүлж өсгөдөг сайхан уламжлалтай. Эхийн сүүнд нялх хүүхэд бойжиж торних, өвчин эмгэгээс хамгаалах дархлаа тогтооход шаардлагатай шим ба эрдэс бодисууд, аминдэм, фермент цогцоор агуулагдаж байдаг эрдэнэ - тэжээл. Тэрчлэн нялх балчираас эхлээд олон өвчнийг эхийн ус - шээсээр (мөнхийн ус ч гэдэг) анагаадаг уламжлалтай, өдгөө ч хэрэглэдэг. Дээр үед алс хол аян жин тээх, мал туух, цэрэгт явахад эхийн усаар арвайн гурил зуурч буурцаглаад, төрсөн газрын чулуутай хамт авч явдаг байв. “Эхтэй хүн энддэггүй” гэдэг.

Мөнгөн домбонд шүүдрийн дусал хурааж чанасан цайг алтан аяганд амсар дүүрэн хийж аав, ээждээ уулгаад хоёр мөрөн дээрээ суулгаад явах юм шиг хий мөрөөдөхийн оронд энэ яваа насанд нь сэтгэл амар байлгах нь чухал. Эцэг, эхээ мөр бүтэн, гэдэс цатгалан, орох оронтой, үр хүүхдийн талаар муу үг дуулж санаа сэтгэл зовохгүй байлгавал хэн хэндээ дээдийн жаргал болно. Бидний эцэг, эх үр хүүхдийнхээ төлөө ямагт санаа тавьж байдгийн нэг илрэл нь тэдний эрх эргүүлж маани уншдаг уламжлал юм. “Ум Ма Ни Бад Мэ Хум” гэдэг нь эртний Энэтхэгийн газар тариалангийн шүтлэг - эхийн умай шүтэх шүтлэгээс уламжлалтай. Ум Хум хоёр нийлэх болтугай. Өөрөөр хэлбэл, эр, эмийн ажил хийх болтугай гэсэн утгатай тантар (буддын шашны нэг урсгал)-ын ёсны нэг томьёолол бөгөөд үүнийгээ тэд буян хийж хойт насандаа сайн төрлийг олно гэж итгэдэг аж хэмээн гүн ухаантан Ч.Жүгдэр агсан бичсэн билээ. Энэ үгийн цаад утга нь аав, ээж, үр хүүхэд амар тайван, урт удаан наслаасай гэсэн санаа юм.

Монголчууд хүүхэд төрөхийг “хоёр яс хагацах, хоёр яс салах” гэдэг ч бас гүнзгий утгатай. Сэтгэл тайван бол бие амар. Мэргэдийн хэлснээр “Бурхан ч сэтгэлээс гарна, Буг ч сэтгэлээс бүтнэ”. Аав, ээж хоёр - миний бурхан.

Монголчуудын эртнээс уламжилж ярьж, хэлж, бичиж ирсэн “Ноорхой ч гэсэн гэр минь, навсгар ч гэсэн ээж минь”, “Арван сар гэдсэндээ тээж, ангир шар уургаа хөхүүлж өсгөсөн ээж минь” гэсэн санааширлын үгийг санаж бай. Эрдэмтдийн судалгаагаар өнөө үеийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн гол дайсан бол:

Нэгд: Тамхинд хордож, архинд балагтаж, мансууруулах бодист хөнөөгдөх. Энэ биеэс

эхлээд үр удамд хар муу үр дагавартай энэ гурван дайснаас хол байх.

Хоёрт: Сүүлийн үеийн эрдэмтдийн судалгаагаар эмэгтэй хүний эрүүл мэндэд, ялангуяа сав (умай)-ны, хөхний хорт хавдрын гол эх үүсвэр нь үр зулбуулах, тэр тусмаа мэргэжлийн бус аргаар үр хөндүүлэх гэж үзэж байна. Ямар их эрдэм номтой, эр чадалтай, босоо хиймэртэй болох үрс хорвоод мэндлэлгүй амиа аав, ээжээрээ таслуулж байгааг бодоход цэвэр монгол хүний сэтгэлд багтахгүй нүгэл, хүний мөсгүй үйл шүү.

Гуравт: Охид хүүхнүүд жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийг мэргэжлийн эмчийн зөвлөмжгүйгээр хэрэглэж байгаа нь бас л уршиг тарьж байна. Ээжүүд окидоосоо хөндий, нарийн үйлээ шивнэж ярилцдаг монгол уламжлал алдагдаж байна.

Дөрөвт: Эмэгтэйчүүд өнгө зүсэндээ хэт анхаараад дотор талдаа анхаарахгүй байна. “Тоо үзэсгэлэн гэдэг нэгэн цагийн үзэх нүдний баясал. Оюун ухаан гэдэг нэгэн насны амьдрах замын үнэн”. “Царайны сайхнаар цай сүлэхгүй”. “Үзвээс нүд булаах, Сонсвоос чих булаах, Бариваас гар булаах, Санаваас сэтгэл булаах” (Д.Равжаа).

7. Монгол ардын сурган хүмүүжүүлэх арга ухааны үндэс

1. Хүүхдээ зөв хайрлах (хайр нь дотроо хал нь гаднаа байх), хэт эрхлүүлэхгүй байх (буруу эрхэлсэн хүүхэд бухын хүзүүнээс хатуу).
2. Хүүхдийг элдэв муу зуршил, үйлээс хамгаалах.
3. Эцэг эх, ахмад хүмүүс, ах эгч нарын сайн чанар, ажил үйлсээр үлгэрлэх.
4. Хүүхэдтэйгээ хамт ажил үйл хийх (хамт ном унших, зураг зурах, дуулах, оёх хатгах, хоол унд бэлтгэх).
5. Хамт тоглож наадах, танин мэдэхүйн учир холбогдолтой шатар, даам, шагайгаар тоглох.
6. Амьдрах ухаанд сургах, юмхнаар юм хийх, мал маллах, тариа ногоо тарих.
7. Хүүхдийнхээ авьяас чадвар, хүч чадлыг илрүүлж, ойлгуулах (бардам бандиар “банзрагч” уншуул, бардам хүүхнээр пансаар хувцас эсгүүлж оёул гэсэн үг бий).
8. Хүүхдийг чих зөөлөнтэй, өөрөөр хэлбэл аав ээжийн үгийг сайн сонсдог, хэлснийг нь биелүүлдэг, биелүүлэхийн төлөө мэрийж ажилладаг болгох.
9. Хүүхдээсээ муу үйлийг нуулгүй хэлэх, муу үйл хийх, түүнд орж орооцолдохоос

- сэргийлэх ухаарлыг төлөвшүүлэх, алив үйлд шунал тачаалгүй болгох,
10. Хүүхдээ амьдралын турш дурсаж санаж байх, баярлаж бахархаж байх эрдэм номтой, ажил төрөлтэй, бүтээлтэй болгож хүмүүжүүлэхийг эрхэмлэхэд оршдог.
 11. Эцэг, эх хүүхдийн дэргэд хэрэлдэж, зодолдох, элдэв бусармаг үг яриа гаргах, агсам тавих нь үр хүүхдийн хүн чанарыг эвдэж, дайжуулдаг. Ийм үед эвээр ярилцаж салаад, эргэж тойрч, харж хандаж байсан нь дээр.
 12. Нөхөр, эхнэр хоёр бие биенээ “Та” гэж байвал наанаа нэг үг ч гэсэн цаанаа хайр хүндэтгэл илэрхийлдэг.
 13. Жирэмсэн эхийг маш сайн хүндэтгэж, сувилж, баяр хөөртэй байлгаж, айдас хүйдэст автуулахгүй амар тайван төрүүлэх. “Эрүүл” эхээс л эрүүл чийрэг хүүхэд төрдөг.

Манай өвөг дээдэс, бидний аав ээж “буян, нүгэл, сайн, муу, сайхан, муухай, болно, болохгүй” гэдэг үгний учир утгыг гэрийн нөхцөлд амьдрал дээр ойлгуулдаг уламжлалтай. Ганц жишээ хэлэхэд аав ээж, ах эгч, ахмадууд, багш, эрдэм номтой, танихгүй хүмүүсийн дэргэд насаар дүү хүн тамхи татах, архи дарс уухыг цээрлэдэг байв.

Монголчууд дээр үеэс хоол, ундаа улирлын байдалд зохицуулж идэж уудаг сайхан уламжлалтай байсан. Өвөл, хаврын улиралд шим шүүс сайнтай хоол цай голдуу; зун намрын улиралд өөх-тос багатай ямааны мах, борц, айраг, тараг, сүү цагаан идээ хэрэглэдэг. Урин дулааны улиралд хоол хүнсэндээ сонгино, сармис, хөмүүл зэрэг халуун чанартай хольц хэрэглэхийг, ялангуяа залуу насныханд хориглодог байв.

Монголчууд архи хэрэглэж эхэлсэн тэр үеэс ууж согтуурахтай тэмцэж ирсэн.

“Балай их уувал өвчин биш үү.
Бага зэрэг уувал жаргал биш үү.
Бахархаж шунавал эргүү биш үү.
Балмад их согтвол галзуу биш үү.
Үргэлж уувал улиг биш үү.

Өсөд үүнийг тэвчвэл билэг биш үү” (“Чингис богдын есөн өрлөгтэй, өнчин хүүгийн цэцэлсэн шастираас”. Лу - Алтан товч. УБ. 1990. Х -89).

“Дөч хүрээд дөнгөж амс.
Тавь хүрээд тааруулж балга.
Жар хүрээд жаргаж хүрт” гэх юмуу

“Архи арван тамтай, тамхи таван тамтай” гэж анхааруулж сургадаг. Дорно дахины ном

зохиолд “архи уусан хүн эхэндээ тогос шиг ааш араншинтай байдаг, удалгүй сармагчин шиг тавтиргүй болдог, хэсэг хугацааны дараа арслан шиг авир гаргадаг (агсам тавина, зодоон цохион хийнэ, алж талахаас ч буцахгүй), эцэст нь бохир заваан бүхэнтэй хутгалдаж гахай шиг болдог” гэсэн байна.

Английн түүхч эрдэмтэн Ж.Саундерс гэгч “Монголын байлдан дагуулал” номондоо “Их Чингисийн бие бялдар, хүч чадлыг удам угсааныхан нь өвлөн авсангүй. Тэдний нас архины архаг донтолтоос болж ихэнхдээ маш богино байлаа” хэмээжээ. Өдгөө манай хүүхэд залуучуудын оюун ухааныг хордуулж, хүн чанарыг алдагдуулж, амьдралыг нь сүйрүүлж буй хүчин зүйл бол архи, тамхи, мансууруулах төрлийн бодисын хэрэглээ болжээ. Архи, тамхи, хар тамхи - мансууруулах бодис нь хүний оюун ухаан, сэтгэл санаа, бие махбодыг, үр удмыг хөнөөх нөлөөтэйг ухаармаар, бодмоор, санамаар байна.

8. Ном дор мөргөмүү.

Монгол хүний нэн чухал уламжлалын нэг нь үр хүүхдээ бага балчираас нь намуун дөлгөөн ааш авиртай, хүний мөс чанар сайнтай, эрдэм номтой хүн болгохыг хичээдэгт оршдог. Үнэндээ “ном мэдэхгүй хүн ном уруу шагайвал хот уруу чоно өнгийсөнтэй адил” гэх юмуу “ном гэдэг мэддэгт мэргэн цоохор, мэдэхгүйд эрээн цоохор” гэдэг үг утгаа ном сур, ном унш гэсэн ёж санаа. Монголчууд багш, ном, шавь гуравт мөргөдөг. “Ноёд ноёд гэмээ нь нутаг зуураа хүндтэй, номтой ламын шавь нар газар болгон хүндтэй” (Д.Равжаа).

Их эрдэмтэн Ц.Дамдинсүрэн агсан

“Хар гэрт ном бий,
Хазгар өвгөнд эрдэм бий,
Хахир говьд эрдэнэ бий,
Хамаагүй басаж болохгүй”.

“Номын утга нь тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн, номыг унших нь тэнгэрт нисэж, дэлхийг тойрч, далайд хөвөх мэт” гэсэн бол эрдэмтэн, зохиолч Д.Цэвэгмид “Ухаан далай номноос эхтэй”, та бидний сайн мэдэх Оросын их зохиолч М.Горький “ном бол ертөнцийг харах цонх мөн” хэмээсэн байдаг.

Ном бол өтөлсөн, ганцаардаж гуньж гутсан, цаг зав ихтэй үед сайн нөхөр, тэрчлэн залуу зандан насанд амьдралын сайн мууг ялгаж таних эрхэм зөвлөгч болдог. Иймээс эцэг эх, ах эгч нар бага насны хүүхдэд хичээлээс гадуур ном (уран зохиолын, шинжлэх ухааны, ёс суртахууны,

байгалийн, түүх, газар зүйн, урлаг - уран сайхны гэх мэт) уншихад нь туйлаас анхаарч туслах ёстой. Хүүхдээ аав, ээж нь дундаа суулгаж байгаад ном унших юмуу хүүхдээрээ уншуулж утга санааг ярилцах, асууж маргах зэргээр ном хаялцаж болно. Хэрэв шүлэг уншвал түүнд гарч буй сонин содон үг, хэллэгт анхаарах, жишээ нь Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг унших явцдаа тэнд гарч буй уул ус, тал хээр, говь цөлийг газрын зураг дээрээс олж мэдэх, Ц.Дамдинсүрэнгийн “Буурал ижий минь”, “Зугаацахаар мордсон нь” шүлгийг уншаад эцэг эх, элгэн садан, нутаг ус гэдэг ямар гайхамшигтай болохыг бишрэх сэтгэл төрнө. Уран зохиолын ном унших, тэр тусмаа сайхан шүлэг (дууны үг) хэлж унших нь хүүхдийн хэл ярианы хөгжилд үлэмж тустай. Хэдийгээр төвд хэлээр ч гэсэн шашны ном уншиж байгаа нь банди нарыг багаас нь унших, цээжлэхэд сургаж байгаа юм. Онцолж хэлэхэд уншиж буй ном зохиол, сурах бичгийг гамтай эдэлж, дараа нь дүү нартаа, мөн шаардлагатай зарим хүүхдэд дамжуулж өгнө.

9. “Эдээр биеэ чимэхээр эрдмээр биеэ чим”.

Дэлхий дахинд сургуулийн насны хүүхэд залуучуудад ямар мэдлэг чадвар эзэмшүүлэх гээд байгааг сонирхуулбал:

1. Унших чадвар. Зөв тод унших, уншсан санаагаа ухаж ойлгох.
2. Тоолох чадвар. Шаардлагатай тоог алдаа мадаггүй бодож, тооцоолох, тодорхой шинжлэх ухааны хөгжлийн суурь болгож ашиглах.
3. Бичих чадвар. Уншсан, бодож сэтгэсэнээ алдаагүй утга төгс тэмдэглэх, хүсэл зорилгоо илэрхийлж бичих.
4. Ярих чадвар. Хүмүүсийн үйл ажиллагааны бүх л хүрээнд ярих чадвар шаардагддаг, зөв, соёлтой, товч, оновчтой, ойлгомжтой, бүтээлч ярих.
5. Сонсох чадвар. Харилцаж байгаа хүнийхээ нас, хүйс, бэл бэнчин, эрдэм чадлыг харгалзахгүйгээр ярьсныг нь сонсож, зохих хариу өгөх, хүсэлтийг биелүүлэх.
6. Харилцах чадвар. Ямар ч хүн бусадтай идэвхтэй, зорилготой харилцаж байж ажил үйлээ бүтээдэг; чөлөөтэй, илэн далангүй, гэвчээртэй ярилцаж, соёлтой харилцах. Нийгмээс ангид, зон олонтой харилцдаггүй хүн гэж байхгүй. “Нийгмээс ангид хүн нэг бол бурхан, нэг бол араатан” (Аристотель). “айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” гэдэг нь сайн харилцааг илэрхийлсэн үг.

Хөдөө орон нутагт иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэхдээ юуны өмнө төр, засгийн байгууллага, төрийн бус байгууллага (ТББ) хоёрын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах. Тухайлбал, сургууль болгонд байгаа сургууль - цэцэрлэгийн зөвлөл (СЦЗ) (түүнд багш, хүмүүжүүлэгч, сурагч, эцэг эхийн төлөөлөл байгаа), сумын ТББ-тай хамтарч тухайн жилд хийх ажлаа төлөвлөөд орон нутгийн зохих удирдлагуудад танилцуулж, үйл ажиллагааны явцад ямар чиглэлээр ямар дэмжлэг туслалцаа авахаа тохиролцсоны дараа нийтэд танилцуулна. Ингэснээр иргэний нийгмийн байгууллагаас монгол орны ирээдүй болох хүүхэд багачуудад мэдлэг боловсрол олгох, тэдэнд монголын уламжлалт соёл, ёс заншилд үндэслэсэн хүнлэг чанар - хүмүүжил төлөвшүүлэхэд нутгийн ард иргэдийг оролцуулах боломжтой болно.

Нэгд. Сургууль цэцэрлэг, төрийн бус байгууллагууд хамтраад хүүхэд залуучууд, сонирхогчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажил зохион байгуулах болно. Энд боловсрол соёлын ахмад туршлагатай хүмүүс, тэргүүний малчин, тариаланчид, дуучид, хөгжимчдэд шавь оруулах, бүлгэм дугуйлан байгуулж хамруулах зэрэг уламжлалт аргыг ашиглах боломжтой.

Хоёрт. Сургууль цэцэрлэг, албан байгууллага, айл өрхийн хашаа талбайг цэвэр цэмцгэр байлгах, цэцэрлэгжүүлэх ажилд хамтран оролцох нь монгол хүний тусч уламжлалын нэг хэлбэр мөн. Тэгээд ч монгол хүн хэзээний айл саахалтаараа хамтардаг, хамаг ажлаа амжуулдаг.

Гуравт. Төрийн бус байгууллага хүүхэд залуучуудад номоор үйлчлэх үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахад идэвхтэй оролцож болно. Сургуулийн ба нийтийн номын сантай хамтраад айл өрх, хувь хүмүүст ном хугацаатай өгч уншуулах, малчид, улирлын ажилчдад явуулын номын сангаар үйлчлэх, уншигчлын зөвлөгөөн хийх гэх мэт олон ажил байж болно.

Дөрөвт. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн бус байгууллага ярилцаж байгаад “цэвэр гар” гэсэн нийтийг хамарсан ажил зохион байгуулж болно. Гар бол хүний амьдралд гайхамшигийг ч бүтээдэг, бас гай зовлонг ч тарьдаг эрхтэн. Бохир гарын өвчин гэгддэг шар өвчнөөс эхлээд гэдэс дотрын олон аюулт өвчин гараар, гарын оролцоотой дамжиж халдварладаг. Иймээс нийтээрээ монгол уламжлалаа дагаж жилдээ нэг удаа гар зөрүүлж золгоод түүнээс хойш уулзахдаа гар барихгүйгээр амар мэндээ үгээр, дохио зангаагаар илэрхийлж заншмаар байна.

Тавд. Гэр орондоо, олон нийтийн газар биеэ

зөв авч явах, соёлтой харилцах, “хүүр, сэг гичий, хулгайч, худалч, луйварчин, пиздаа, янхан, өлөгчин, нохой, гөлөг г.м.” муухай үг хэлэхийг цээрлэдэг, ялихгүй юманд уурлаж уцаарлаж сэтгэл мэдрэлээ зовоохгүй байх талаар санаа тавьж хамтарч ажиллах.

Зургаад. Янз бүрийн өвчин эмгэгт нэрвэгдэх, нас богиносох, бэртэж гэмтэх, ухаан санаа самуурахын гол шалтгаан болох архи, тамхи, мансууруулах бодисоос ангид “эрүүл хамт олон” болох.

Долоод. Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, ахадсан хөдөлмөр хийлгэхгүй байх, ялангуяа эмэгтэй хүүхдийг бэлгийн хүчирхийлэл болон хүсээгүй жирэмслэлтээс хамгаалах чиглэлээр төрийн ба төрийн бус олон нийтийн байгууллага хамтарч соён гэгээрүүлж ажиллах. Хүн бүр оюун санаагаа ариусгаж, сайн сайхан үйлд төвлөрүүлж миний, манай, таны, танай хамт олны, айл гэрийн сайн сайхан бүхэн, аз жаргалын гал голомт бас хар бараан үйлс ч хажууд, та бидний гэр оронд байдаг гэдгийг ухаарч, санаж, ажиллаж амьдрах. Энд амьдралын мөнхийн багш болсон (И.Гёте) туршлагаас суралцаж, туршлага буй болгож хуримтлуулах, сурталчилж, солилцож, түгээн дэлгэрүүлэх нь эрхэм.

Сонирхуулахад Зөвлөлт - Оросын нэрт яруу найрагч Е.Евтушенко Монголчуудын ичимтхий зан чанарыг үндэсний бөгөөд бүх хүн төрөлхтний сайн сайхан чанарын эн тэргүүний шинж гэснийг бодууштай. “Ичих булчирхайгүй амьтад олширч” гэж дээр доргүй ярьж бичиж байна шүү.

Тэрчлэн Данийн олон улсын хөгжлийн тусламж /ДАНИДА/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслахаар ирсэн эрдэмтэд манай сургууль, цэцэрлэг, айлуудаар олонтоо орж гардаг байсан, тэд монгол хүүхдийн тэсвэр хатуужил /ялангуяа хөдөөний/, хөдөлмөрч чанар, тэрчлэн айлуудад өвгөд, хөгшид, настангууд амар тайван, хүү, бэр, охин, хүргэн нартайгаа хамт амьдарч байгааг хараад гайхдаг, их бахархдаг байв. Тэр их өндөр боловсролтой, хөгжилтэй амар тайван орон гэхэд аав, ээж нь тэтгэвэрт гармагц л тэтгэмжийн газарт явуулдаг аж. Үүнтэй уялдуулж “Аав, ээжээ асарч торддог хүн амьдралдаа аз жаргалтай байдаг” (М.Т.Цицерон) гэснийг санаж, төрүүлж өсгөсөн аав, ээжээ бурхан гэж, төрсөн газраа эх орон минь гэж бодож сүжиглэж бай. Аав, ээж ахмад настанд асрах тордох, болж бүтэхээр нь туслах, хүндэлж энэрэх сэтгэлээр хандах хүмүүжил доголдож байна шүү.

Хүүхэд залуус маань амьдралын сайн сайхныг ойлгож, түүндээ бахархаж, муу муухай ажил үйлс, хор хөнөөлтэй үйлдлийг ухаарах, өөрийнхөө, хамт олныхоо, нийгмийнхээ ирээдүйн хөгжлийг тоймлон харах чадвар нэн чухал байна. Уламжлал шинэчлэл хоёр салшгүй холбоотой. Хүүхэд залуучууд сурч боловсрох, ажил хөдөлмөр хийх, хамт олон, нийгмийн дунд амьдрахдаа эрхээ эдлэхийн хамт үүргээ ухамсарлах, ёс суртахуунтай байж гэм хүндлэл, нэр хүнд хүлээнэ. “Нэр хугарахаар яс хугар” гэдэг.

ДҮГНЭЛТ

Орчин үед бие хүн ямар байх талаар эрдэмтэн мэргэд дараах дүгнэлтэд хүрчээ.

- Оюун санаа, бие махбод, сэтгэцийн хувьд эрүүл байх (эрүүл монгол хүн)
- Эрдэм мэдлэг, хүч чадалдаа тохирсон хөдөлмөр хийх
- Ёс суртахууны хүмүүжилтэй байх
- Мэдлэг боловсрол
- Дотоод сэтгэлгээ ариун, шударга, хүнлэг, тусч
- Харилцааны соёл эзэмших
- Хөх толбот монгол хүний шинж - тэсвэр тэвчээр, хөдөлмөрч, шударга зан, байгальд зохицон амьдрах чадвар, хүмүүнлэг чанар. Энэ шинж чанараа уламжлан хадгалах.
- Ахмад үеийнхний эрхэм нандин үйлс - эх оронч үзэл үнэмшилтэй болох.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Дамдинсүрэн, Ц., Цэнд, Д. (Ред). (1976). *Монголын уран зохиолын тойм*. Хоёрдугаар дэвтэр. Улаанбаатар
- Гаадамба, Ш. (1976). *Нууц товчооны нууцаас*. Улаанбаатар
- Арьяасүрэн, Ч., Нямбуу, Х. (1961). *Монгол ёс заншлын дунд тайлбар толь*. Улаанбаатар
- Лувсанцэрэн, Г., Жамбал, А. (2011). *Гүн ухаантан Чимидийн Жүгдэр*. Улаанбаатар
- Саундерс, Ж. (1992). *Монголын байлдан дагуулал*. Улаанбаатар
- Дүнчээ, С. (2005). *Хүүхдийн хүмүүжил, хөгжил*. Улаанбаатар